



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/512

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын Ажлын албаны эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 58,359,343.0 (тавин найман сая гурван зуун тавин есөн мянга гурван зуун дөчин гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ажлын алба (Э.Алтанбагана)-нд зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 92 нэр төрлийн 51,238,343.0 (тавин нэгэн сая хоёр зуун гучин найман мянга гурван зуун дөчин гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 4 нэр төрлийн 7,121,000.0 (долоон сая нэг зуун хорин нэгэн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ажлын алба (Э.Алтанбагана)-нд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В. Оюумаа

В.ОЮУМАА



92	MT1680 1.6ширээ	10	ш	1	251,750.00	251,750.00	251,750.00	0	Актлах	Устгах	Устгах	Устгах
93	MT1680 1.6ширээ	10	ш	1	251,750.00	251,750.00	251,750.00	0	Актлах	Устгах	Устгах	Устгах
94	Индэр	14	ш	1	1,278,004.00	1,278,004.00	1,278,004.00	0	Актлах	Устгах	Устгах	Устгах
95	ИОТ /хурлын индэр/	11	ш	1	650,000.00	650,000.00	650,000.00	0	Актлах	Устгах	Устгах	Устгах
96	Сейф SF680-3ЕКК	11	ш	1	1,425,000.00	1,425,000.00	1,425,000.00	0	Актлах	Устгах	Устгах	Устгах
	Тавилга, эд хогшлын дүн			29		13,055,157.00	13,055,157.00	0			Татах	Татах
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн					58,359,343.00	58,359,343.00					
	Үүнээс: Худалдах хөрөнгө							92				
	Актлах хөрөнгө							4				
	Татан төвлөрүүлэх хөрөнгө											

Ашиглах
Болмжгүй